



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/149/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 9999-3365

Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Г.Заяа
Утас: 9203-8288

Цахим хаяг: zayaq@audit.gov.mn

Аудитор Г.Чулуунбаатар

Утас: 9908-4581

Цахим хаяг: chuluunbaatarg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЦАГААНЧУЛУУТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ОЮУНЧИМЭГ-Т

2022-02-24 № 1302/214.
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302/156

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>51,599.24</u>	<u>48,268.99</u>
33	АВЛАГА	00.00	800.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	51,599.24	47,468.99
351	Түүхий эд материал	7,531.15	6,235.64
35110	Тусгай зориулалттай материал	6,804.65	5,583.39
35130	Эм боох материал	726.50	652.25
354	Хангамжийн материал	31,638.09	33,343.35
35410	Бичиг хэргийн материал	1,100.80	1,319.50
35420	Аж ахуйн материал	1,147.75	2,098.20
35430	Сэлбэг хэрэгсэл	1,106.00	130.00
35440	Түлш, шатах тослох материал	463.50	463.50
35450	Барилгын засварын материал	3,115.95	4,983.80
35460	Хүнсний материал	5,500.75	7,233.31
35470	Бусад хангамжийн материал	19,203.34	17,115.04
35600	Мал амьтад	12,430.00	7,890.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>534,718.35</u>	<u>520,327.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	534,718.35	520,327.00
392	Биет хөрөнгө	525,931.35	511,870.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	526,948.32	526,948.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,371.71	-44,057.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,134.28	37,537.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,403.73	-24,083.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,866.08	28,766.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,961.55	-15,980.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,712.20	1,712.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,712.20	-1,712.20
39217	Ном	2,719.67	2,739.57
393	Биет бус хөрөнгө	8,787.00	8,457.00
39301	Програм хангамж	1,650.00	1,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-165.00	-495.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,302.00	7,302.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>586,317.59</u>	<u>568,595.99</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>586,317.59</u>	<u>568,595.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	586,317.59	568,595.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		39,267.50	39,267.50
51101	Өмч: - төрийн	39,267.50	39,267.50
512	Хуримтлагдсан үр дүн	540,332.83	522,611.23
51210	Өмнөх үеийн үр дүн	540,332.83	540,332.83

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-17,721.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,717.26	6,717.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	586,317.59	568,595.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мян.төг/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	298,291.02	315,357.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	298,291.02	315,357.45
120	Нийтлэг татварын бус орлого	17,457.62	14,774.35
120009	Бусад орлого	110.00	13,345.75
122	Тусламжийн орлого	42,423.60	42,372.40
122002	Хандив тусламж /гадаад/	42,423.60	42,372.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	238,409.80	258,210.70
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	238,409.80	258,210.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	300,573.68	333,079.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	300,573.68	333,079.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,647.36	320,825.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,382.09	193,470.43
210101	Үндсэн цалин	190,382.09	124,401.51
210102	Нэмэгдэл	00.00	55,123.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	715.05
210104	Урамшуулал	00.00	13,230.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,816.67	25,446.89
210201	Тэтгэврийн даатгал	15,844.57	18,021.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,834.67	2,001.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,467.73	1,547.76
210204	Ажилгүйдлийн даатгал	327.58	344.51
210205	Эрүүл мэндийн даатгал	3,342.12	3,531.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,501.07	37,781.29
210301	Гэрэл, цахилгаан	1,299.96	2,064.00
210302	Түлш, халаалт	35,048.72	35,420.50
210303	Цэвэр, бохир ус	152.40	296.80
2104	Хангамж, бараа материалын зардал	12,644.04	19,443.54
210401	Бичиг хэрэг	537.80	1,804.60
210402	Тээвэр, шатахуун	1,090.40	626.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	696.30	715.74
210404	Ном, хэвлэл	39.20	125.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,434.90	2,746.05
210408	Бараа материал акталсны зардал	8,845.44	13,425.06
2105	Нормативт зардал	12,311.66	15,985.59
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65.50	2,280.75

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	12,246.16	13,704.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	638.50	3,686.15
210604	Урсгал засвар	638.50	3,686.15
2107	Томилолт, зочны зардал	762.00	400.00
210702	Дотоод албан томилолт	762.00	400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690.00	803.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	540.00	263.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,901.32	23,809.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	419.90	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,481.42	23,809.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,926.32	12,253.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	9,217.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,845.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	372.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,926.32	3,035.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2,282.66	-17,721.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,696.96	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	78.30	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,618.66	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,696.96	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-12,979.62	-17,721.60

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,267.50	6,717.26	540,332.83	586,317.59
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,267.50	6,717.26	540,332.83	586,317.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,267.50	6,717.26	540,332.83	586,317.59
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,721.60	-17,721.60
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,267.50	6,717.26	522,611.23	568,595.99

/мян.төг/

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	280,943.40	313,928.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,943.40	313,928.85
120	Нийтлэг татварын бус орлого	110.00	13,345.75
122	Тусламжийн орлого	42,423.60	42,372.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	238,409.80	258,210.70
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	238,409.80	258,210.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	277,960.50	304,511.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,960.50	304,511.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,034.18	292,258.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,382.09	194,270.43
210101	Үндсэн цалин	131,722.96	125,378.31
210102	Нэмэгдэл	41,839.46	55,075.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500.00	715.05
210104	Урамшуулал	16,319.68	13,101.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,816.67	25,446.89
210201	Тэтгэврийн даатгал	15,844.57	18,021.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,834.67	2,001.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,467.73	1,547.76
210204	Ажилгүйдлийн даатгал	327.58	350.80
210205	Эрүүл мэндийн даатгал	3,342.12	3,525.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,960.27	41,359.29
210301	Гэрэл, цахилгаан	2,882.46	4,962.00
210302	Түлш, халаалт	34,958.72	35,420.50
210303	Цэвэр, бохир ус	1,119.10	976.80
2104	Хангамж, бараа материалын зардал	3,645.51	7,021.34
210401	Бичиг хэрэг	741.70	949.10
210402	Тээвэр, шатахуун	890.01	626.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	696.30	715.74
210404	Ном, хэвлэл	39.20	125.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,776.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,278.30	1,828.40
2105	Нормативт зардал	16,088.88	20,393.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,984.00	2,456.50
210502	Хоол, хүнс	11,550.88	15,437.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,554.00	2,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	999.35	1,000.00
210604	Урсгал засвар	999.35	1,000.00
2107	Томилот, зочны зардал	762.00	400.00

210702	Дотоод албан томиллолт	762.00	400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	651.80	542.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	501.80	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	542.20
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	727.61	1,824.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	727.61	1,824.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,926.32	12,253.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	9,217.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,845.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	372.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,926.32	3,035.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,982.90	9,417.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,982.90	9,417.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,982.90	9,417.70
2200	Дотоод эх үүсвэрээр	2,982.90	9,417.70
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,982.90	9,417.70
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,982.90	-9,417.70
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,969.20	277,907.08	313,922.30	297,547.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	313,969.20	277,907.08	313,922.30	297,547.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,969.20	277,907.08	313,922.30	297,547.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,515.00	190,382.09	199,832.70	194,270.43
210101	Үндсэн цалин	130,770.00	131,245.64	126,842.40	125,378.31
210102	Нэмэгдэл	48,211.10	42,316.78	56,513.90	55,075.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500.00	500.00	2,250.00	715.05
210104	Урамшуулал	14,033.90	16,319.68	14,226.40	13,101.35
2102	Ажил олгогчоос нийгмийн	26,124.50	22,816.67	26,977.50	25,446.89

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	даатгалд төлөх шимтгэл				
210201	Тэтгэврийн даатгал	18,383.90	15,844.57	18,984.10	18,021.03
210202	Тэтгэмжийн даатгал	1,935.20	1,834.67	1,998.30	2,001.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,548.10	1,467.73	1,598.70	1,547.76
210204	Ажилгүйдлийн даатгал	387.00	327.58	399.70	350.80
210205	Эрүүл мэндийн даатгал	3,870.30	3,342.12	3,996.70	3,525.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,772.40	38,960.27	43,772.60	41,359.29
210301	Гэрэл, цахилгаан	4,963.10	2,882.46	4,963.10	4,962.00
210302	Түлш, халаалт	37,581.30	34,958.72	37,581.50	35,420.50
210303	Цэвэр, бохир ус	1,228.00	1,119.10	1,228.00	976.80
2104	Хангамж, бараа материалын зардал	3,063.30	4,185.01	3,030.50	3,563.24
210401	Бичиг хэрэг	743.90	1,270.70	690.40	949.10
210402	Тээвэр, шатахуун	894.10	890.01	809.20	626.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700.00	696.30	745.50	715.74
210404	Ном, хэвлэл	55.80	52.10	51.80	145.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	669.50	1,275.90	733.60	1,126.40
2105	Нормативт зардал	42,667.00	15,472.28	35,960.30	19,743.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44.30	2,015.00	1,208.30	1,806.50
210502	Хоол, хүнс	42,064.80	10,903.28	34,234.20	15,437.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	557.90	2,554.00	517.80	2,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000.00	999.35	1,000.00	1,000.00
210604	Урсгал засвар	2,000.00	999.35	1,000.00	1,000.00
2107	Томилолт, зочны зардал	836.90	762.00	800.00	400.00
210702	Дотоод албан томилолт	836.90	762.00	800.00	400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	502.20	2,841.80	345.20	542.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	502.20	1,041.80	00.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	345.20	542.20
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,800.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1487.90	1487.61	2.20	11.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,487.90	1,487.61	2,203.50	11,221.80
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	313,969.20	277,907.08	313,922.30	297,547.75
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	313,969.20	277,907.08	313,922.30	297,547.75
131001	Улсын төсвөөс санхүүжих	45,772.40	39,959.62	44,772.60	42,359.29
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	268,196.80	237,947.46	269,149.70	255,188.46
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.02	00.02	00.02	00.02
620002	Гүйцэтгэх ажилтан	00.01	00.01	00.01	00.01

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/мян.төг/
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,345.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,345.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,128.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,478.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,776.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	702.00
2105	Нормативт зардал	650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,217.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,845.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	372.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Г.Чулуунбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бага насны хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэн, өсөн хөгжиж буй тархи оюуныг ажиллуулахдаа тэдний өвөрмөц онцлог, мөн чанарт нийцсэн үйлүүдэд хамруулах бөгөөд тэднийг байгаль, нийгэмтэй танилцуулж, сайхан сэтгэлтэй, сайн иргэн болгох суурийг тавих”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 315,357.4 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 4,730.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3,547.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	800.0	800.0
Бараа материал	51,599.24	47,468.99	-4,130.25

Үндсэн хөрөнгө	534,718.35	520,327.00	-14,391.35
Нийт хөрөнгө	586,317.59	568,595.99	-17,721.6
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	586,317.59	568,595.99	-17,721.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	586,317.59	568,595.99	-17,721.6

Авлагын дансны үлдэгдэл 800.0 мянган төгрөг болж өссөн нь 2 ажилтны цалингийн урьдчилгааг суутган тооцоогүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47,468.99 мянган төгрөг болж буурсан нь мал амьтад данснаас зарцуулалт хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 520,327.0 мянган төгрөг болж буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 568,595.99 мянган төгрөг болж буурсан нь хуримтлагдсан үр дүн 17,721.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 313,922.30 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 44,772.60 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгээр 269,149.70 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 42,359.29 мянган төгрөгийн, тусгай зориулалтын шилжүүлгээр 255,188.46 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 13,345.75 мянган төгрөг, нийт 310,893.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 310,893.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 13,345.75 мянган төгрөгийн орлого хүлээн авч 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 149 мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн, зөвлөмжийн хэрэгжилт 98.0 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 2,243.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулсан алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

2022 онд харилцагч байгууллагын төлбөрийн баримтаар /и-баримт/ баталгаажсан ажил гүйлгээг хийх.

Си-Ти-Эс ХХК-ний 1,650.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн болон няравын программыг 2022 онд ашиглах.

Зөвлөмжийн хариуг 2022.10.01-ний өдрийн дотор албан тоотоор ирүүлэх

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цагаанчулуут сумын Хүүхдийн цэцэрлэг	2	2,243.0	-	-	-	-	-	-	2	2,243.0

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЗАЯА

2022.02.25